



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Эрдэнэ сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2022/104/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Дорноговь аймаг 2022 он	Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий Утас: 70522734 Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn Аудитын менежер: У.Оюунтүлхүүр Утас: 70523020 Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn Ахлах аудитор: Э.Энхцэцэг Цахим хаяг: enkhtsetsege@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (705) 2-27-34
Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2022.02.28 № 16/201

танай _____-ны № _____-т

ДОРНОГОВЬ АЙМГИЙН
ЭРДЭНЭ СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Г.АЛТАНЦАЦРАЛ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Эрдэнэ сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Эрдэнэ сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Т.ГАН-ӨЛЗИЙ

010020023

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/сая төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	140,490,727.76	147,122,590.76
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,858,003,017.94	1,749,783,972.84
	Нийт хөрөнгийн дүн	1,998,493,745.70	1,896,906,563.60
	Нийт өр төлбөрийн дүн	-	249,060.00
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,998,493,745.70	1,896,657,503.60
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,998,493,745.70	1,896,906,563.60
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	929,806,106.04	562,880,443.00
	Үйл ажиллагааны зардлын дүн	599,276,602.85	664,716,685.10
	Үйл ажиллагааны үр дүн	330,529,503.19	(101,836,242.10)
	Үйл ажиллагааны бус үр дүн	(328,309.59)	-
	Үйл ажиллагааны нийт үр дүн	330,201,193.60	(101,836,242.10)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	528,431,611.57	1,998,493,745.70
	Тайлант оны үр дүн		(101,836,242.10)
	Эцсийн үлдэгдэл	528,431,611.57	1,896,657,503.60
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	514,195,826.00	557,157,787.00
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	500,914,226.00	550,538,787.00
	Үйл ажиллагааны ЦМГ	13,281,600.00	6,619,000.00
	Хөрөнгө оруулалтын ЦМГ		
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ		
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн		470,828,024.00
	Урсгал зардал		470,828,024.00
	Хөрөнгийн зардал		-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		470,828,024.00
	Орон нутгийн төсвөөс санхүүжих		470,388,024.00
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас		440,000.00

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дорноговь аймгийн Эрдэнэ сумын ЗДТГ-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон байна.Үүнд:

Дэд бүтцийн хангамжийг нэмэгдүүлж, бизнесийн таатай орчныг бүрдүүлэх замаар бизнест шаардлагатай хатуу дэд бүтцийг хөгжүүлж, эрх зүй, эдийн засгийн таатай орчныг бүрдүүлж, бизнесийн хөгжлийг дэмжинэ.

Эдийн засгийн салбаруудын чадавхыг бэхжүүлж, тогтвортой хөгжлийг хангах замаар хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, орон нутгийн нөөцөд түшиглэн үйлдвэрлэл, үйлчилгээ, хоршоог хөгжүүлэн дэмжиж хүн амын эрэлт, хэрэгцээг бүрэн дүүрэн хангана.

Төр, нийгмийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулж, хүмүүнлэг, эрүүл, боловсролтой иргэдийг төлөвшүүлнэ.

Байгаль орчноо хамгаалж, нөөц баялгийг зүй зохистой ашиглан байгалийн тэнцвэрийг хадгална.

Эрхэм зорилго: Засгийн газар, аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлж, цомхон чадварлаг боловсон хүчинтэйгээр төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэж, нутаг дэвсгэрийн аж ахуйн нэгж байгууллагуудын харилцан хамтын ажиллагааг төрийн захиргааны удирдлагаар хангаж ажиллаж, салбар салбартаа үйл ажиллагаагаар тэргүүлэн ажиллана.

Алсын хараа: Үндэсний ёс заншлаа дээдэлсэн, эрүүл, оюунлаг, чинээлэг иргэдтэй, байгальд ээлтэй, бизнесийн таатай орчин бүрдсэн, эдийн засгийн өндөр чадавх бүхий сум байх.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

Ковид-19 цар тахал өвчинтэй холбоотой засгийн газрын тогтоол, шийдвэрүүд шинээр гарч хэрэгжсэн.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Эрдэнэ сумын ЗДТГ-ын нягтлан бодох бүртгэлийг хөтлөх чиг үүрэг бүхий нягтлан бодогч нь тайлант хугацаанд 3 удаа өөрчлөгдсөн байна.

Дөрөв. Аудитын гол асуудал

Тайлант хугацаанд 2,684.9 сая төгрөгийн зардлыг зардал хооронд шилжүүлэн, зориулалт бусаар зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 50 нэрийн, 787.9 сая төгрөгийн анхны өртөгтэй хөрөнгийн ашиглах жилийг хасах тэмдэгтэй, зарим хөрөнгүүдийн ашиглах жилийг санхүүгийн программд оруулаагүй бүртгэсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн харилцах дансанд Мандговь ХХК-иас өгсөн 3.0 сая төгрөгийн хандивыг төвлөрүүлж, бичиг хэрэг, засварын материал худалдан авч зарцуулсан байна.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 491.6 сая төгрөгийн 28 ажил гүйлгээнээс 394.6 сая төгрөгийн 24, зарлагын 114.9 сая төгрөгийн 15 ажил гүйлгээнээс 73.0 сая төгрөгийн 9 ажил гүйлгээг, хөрөнгө зарцуулах тухай 6.0 сая төгрөгийн 13 тушаалыг тус тус мэдээлээгүй байна..

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

Долоо. Аудитын илрүүлэлт:

Аудитаар 6.8 сая төгрөгийн 6 алдаа, зөрчил илрүүлснээс, 1.1 сая төгрөгийн 2 алдааг залруулж, 2.7 сая төгрөгийн 3 албан шаардлага өгч, 3.0 сая төгрөгийн 1 зөвлөмж хүргүүллээ. Үүнд:

7.1. Залруулсан алдаа

1. Үндсэн хөрөнгийн бүртгэл 45 нэрийн хөрөнгийг ангиллын дагуу бүртгээгүй, мөн 0.9 сая төгрөгийн анхны өртөгтэй программ хангамжийг бусад биет бус хөрөнгийн дансанд бүртгэснийг программ хангамжийн дансанд шилжүүлэн бүртгүүлж залруулав.

2. Санхүүгийн тайланд НИК ХХК-д төлөх 0.2 сая төгрөгийн шатахууны зардлын өглөгийг тусгаагүй орхисныг байгууллагад төлөх өглөгөөр тусгаж залруулав.

7.2. Албан шаардлага

1. Тайлант хугацаанд 2,684.9 сая төгрөгийн зардлыг зардал хооронд шилжүүлэн, зориулалт бусаар зарцуулсан байна.

2. Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 50 нэрийн, 787.9 сая төгрөгийн анхны өртөгтэй хөрөнгийн ашиглах жилийг хасах тэмдэгтэй, зарим хөрөнгүүдийн ашиглах жилийг санхүүгийн программд оруулаагүй бүртгэсэн байна.

3. Цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 491.6 сая төгрөгийн 28 ажил гүйлгээнээс 394.6 сая төгрөгийн 24, зарлагын 114.9 сая төгрөгийн 15 ажил гүйлгээнээс 73.0 сая төгрөгийн 9 ажил гүйлгээг, хөрөнгө зарцуулах тухай 6.0 сая төгрөгийн 13 тушаалыг тус тус мэдээлээгүй байна.

7.3. Зөвлөмж

Нэмэлт санхүүжилтийн харилцах дансанд Мандговь ХХК-аас өгсөн 3.0 сая төгрөгийн хандивын орлогыг төвлөрүүлж, бичиг хэрэг, засварын материал худалдан авахад зарцуулсан зөрчилд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 “Албан тушаалтан, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага нийтийн хэрэгцээнд зориулан иргэн, хуулийн этгээдээс бэлэг, бусад санхүүгийн туслалцааг авах, хүсэхийг хориглоно” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах талаар зөвлөмж хүргүүллээ.

8.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	Эрдэнэ сумын ЗДТГ	1	1	-	-	1	-	-	-
НИЙТ									

8.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	Эрдэнэ сумын ЗДТГ	6	6.8	2	1.1	0	0	3	2.7	1	3.0
	НИЙТ	6	6.8	2	1.1	0	0	3	2.7	1	3.0